



ХЭНТИЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО

Хэнтий аймаг, Чингис хот
Тэмүүжингийн гудамж, утас: 70563030
E-mail: khentiinam@yahoo.com

2022.04.12 № 04
танай _____-ны № 371 -т

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хэнтий аймгийн Ардчилсан намын хорооноос Аймаг нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 37.8 дахь хэсэгт заасны дагуу орон нутгийн ээлжит бус, нөхөн, дахин сонгуулиар нам эвсэл болон бие даан нэр дэвшигч нь төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ гэж заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хүргүүлж байна.

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН

ДАРГА



Т. БЯМБАБААТАР

ХЭНТИЙ АЙМАГ



ХЭНТИЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМААС 2022 ОНЫ ОРОН НУТГИЙН
НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2022.04.12



ХЭНТИЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМААС 2022 ОНЫ ОРОН НУТГИЙН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ХАН ХЭНТИЙЧҮҮДИЙНХЭЭ ЭРХ АШГИЙГ ДЭЭДЛЭН, ХУВЬ ХҮН, ӨРХ ГЭРИЙН ХӨГЖЛИЙГ ЭРХЭМЛЭЖ, ҮНДЭСНИЙ УХАМСАР, СОЁЛЫН ӨВИЙГ ДЭЛГЭРҮҮЛЖ, БАЯЛАГ БҮТЭЭГЧ, ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ, АЖИЛТАЙ, ХҮН БҮРД ОРЛОГОТОЙ, ӨРХ БҮРД ӨСӨЛТТЭЙ, БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ НОГООН ЭДИЙН ЗАСАГТАЙ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТЭЭРЭЭ ЗҮҮН БҮСДЭЭ ТЭРГҮҮЛСЭН "ТУЛГУУР ТӨВ АЙМАГ" БОЛОХ ЭРХЭМ ЗОРИЛГОО НОТЛОН ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДАРААХ МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ДЭВШҮҮЛЖ БАЙНА.

НЭГ.ХӨГЖЛИЙГ БҮТЭЭГЧ ХЭНТИЙЧҮҮД /ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ/
"Ажлын байр- Аймгийн хөгжил" чиглэлийг эрхэмлэн хөдөлмөрлөж, эдийн засгийн өсөлтийг өрх бүрээрээ хүртсэн бүтээгч Хэнтийчүүд, бусдад жишиг байх үзэл баримтлалыг мөрдөн ажиллана.

1.1 Хан Хэнтийнхээ иргэн бүрийг үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг төлөвшилтэй болгоход зориулан "Оюунлаг Хэнтийчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2 Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, нутаг орныхоо байгаль, түүх, соёл, уламжлалаараа бахархдаг "Зөв Монгол хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.3 "Хэнтийн ирээдүй -Багшийн хөгжил" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах ажлыг үе шаттай зохион байгуулна.

1.4 Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар сургууль цэцэрлэгийн удирдах албан албан тушаалтаныг томилох, чөлөөлөхөд сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн "Боловсролын зөвлөл"-ийн саналыг үндэслэдэг болно.

1.5 Орон нутгийн үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн боловсон хүчнийг аймгийн МСҮТ-д бэлтгэнэ.

1.7 Төрийн бодлогоор хэрэгжих "Түмэн инженер" хөтөлбөрт Хэнтийчүүдийн суралцах боломжийг эрс нэмэгдүүлнэ.

Т.Батбаяр



1.8 Аймгийн хэмжээнд цэцэрлэгийн шинэ барилга барьж ашиглалтанд оруулах талаар бүхий л боломжоо дайчилан ажиллана. Шаардлагатай цэцэрлэгт их засвар хийж сургуулийн өмнөх боловсролын тэлэлт сургалтыг нэмэгдүүлнэ

1.9 Зайны цахим сургалтаар дээд боловсрол эзэмших иргэд залуусын судалгааг гарган боломжийг олгоно.

1.10 Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах "Зөв дархлаа" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.11 Урьдчилан сэргийлэх үзлэгт суурилсан өндөр үр өгөөж бүхий эрүүл мэндийн тогтолцоог орон нутгийн онцлогт тохируулан шинэчлэн хэрэгжүүлнэ.

1.12 Сумдын эрүүл мэндийн төвүүдийг шинээр барих, барилгад их засвар, өргөтгөл хийнэ.

1.13 Эрүүл мэндийн салбарын эм хангамж, хүний нөөц, удирдлага менежментийн талаар орон нутагт тохирсон бүтэц зохион байгуулалтын бодлого хэрэгжүүлнэ.

1.14 Ахмад настан, тусгай хэрэгцээт иргэдэд /ХБИ/ үйлчилгээ үзүүлэх амралт сувиллын үйлчилгээний нэр төрлийг олшируулан үйлчилгээний чанарт тавих хяналтыг боловсронгуй болгон үйлчилнэ.

1.15 Аймгийн нутаг дэвсгэрт байгаа эмчилгээний чанартай рашаан ус, ургамлыг орон нутгийн хамгаалалтад авч эзэнжүүлэн уламжлалт анагаах ухааны өв санд суурилсан үйлчилгээний брэнд бүтээгдэхүүн, эмийн найрлагад ордог ургамал, эрдэсийн нөөцийг тарималжуулж үржүүлэхийг бодлогоор дэмжинэ.

1.16 Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчилж, үйлчилгээний чанар, хүртээмж шуурхай байдлыг эрс сайжруулна.

1.17 Биндэр суманд олон улсын стандартад нийцсэн төрөх эмнэлэг байгуулна.

1.18 Нэгдсэн эмнэлэгт суурилагдсан орчин үеийн тоног төхөөрөмж дээр ажиллах мэргэшсэн чадвартай өндөр мэргэжлийн эмч нарыг бэлтгэн ажиллуулах.

1.19 Орон нутгийн эрүүл мэндийн салбараар үйлчлүүлэгчдийн бүртгэл дарааллын дугаарыг цахимаар авдаг болгож тус салбарт ажиллагсдад хариуцлага ёс зүйг дээшлүүлэх арга зүйг боловсруулан хэрэгжүүлнэ.

1.20 Архигүй Хэнтийчүүд-2 хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.21 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, хэвшүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн "Эрүүл мэндийг дэмжигч" аймаг болно.

1.22 Гэр бүлийн гишүүн бүрт ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

1.23 Орон нутгийн иргэдээ зээлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хувийн орон сууцтай болгох тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж, ипотекийн 8 хувийн зээлийг үргэлжлүүлэн олгоно.

1.24 Залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн өрхийг түрээсийн орон сууцаар хангах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ..

1.25 Хэнтий нутгаа байгальд ээлтэй түүхэн аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх "Алтан аргамж" хөтөлбөрийг олон нийтээр хэлэлцүүлэн баталж үе шаттайгаар хэрэгжүүлж олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.

Т.Сэнгэ



23171-
СЮА0048

- 1.26 Аялал жуулчлалын 19 голомт, цогцолборуудыг батлагдсан маршрутын дагуу барьж эхлэн эдийн засгийн эргэлтэнд оруулна.
- 1.27 Чингис хотод олон улсын 4-С ангилал зэрэглэл бүхий "Өндөрхаан" нисэх буудлыг аялал жуулчлалын үйлчилгээний бусад байгууламжийн хамт ашиглалтад оруулна.
- 1.28 Аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад дотоодын жуулчпыг татах, орон нутаг, өв соёлоо сурталчлах зорилгоор үндэсний Эвент арга хэмжээг жил бүр зохион байгуулна
- 1.29 Аймгийн төвд , орон нутаг судлах, байгалийн түүх, түүхэн өв соёлын музейн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.
- 1.30 Дадал суманд орчин үеийн технологи бүхий нисэх онгоцны буудал барьна.
- 1.31 Хэрлэнгийн хөдөө аралд "Монголын нууц товчооны өргөө"г барьж байгуулна.
- 1.32 Нутаг орныхоо нэрийг тив, дэлхий, улсад өндөрт өргөсөн тамирчид, уран бүтээлчид, эрдэмтэд, алдартнуудыг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.33 Хэнтий нутгийн байгальд оршиж буй түүхийн дурсгалыг эзэнжүүлэн хамгаалж, тооллого бүртгэлийн мэдээллийн санг боловсронгуй болгоно.

ХОЁР. ӨСӨЛТИЙГ ХҮРТСЭН ХЭНТИЙЧҮҮД /ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ/

Ажлын байр- Аймгийн хөгжил чиглэлийг эрхэмлэн хөдөлмөрлөж, эдийн засгийн өсөлтийг өрх бүрээрээ хүртсэн бүтээгч Хэнтийчүүд , бусдад жишиг байх үзэл баримтлалыг мөрдөн ажиллана.

2.1 Аймгийн ИТХ-аар " Ажлын байр-Аймгийн хөгжил" хөтөлбөрийг улсын эдийн засгийн бодлоготой уялдуулан орон нутгийн төсвийн нэмэлт эх үүсвэрийг бий болгох бодлого хэрэгжүүлнэ.

2.2 Аймгийн гадаад харилцааны бодлогодоо эдийн засгийн түншлэл, худалдааны болон нийгмийн олон талт хэлэлцээрүүдийг байгуулан хэрэгжүүлнэ.

2.3 Технологийн дэвшлийг ашиглах замаар авилгыг мэдээлэх, илрүүлэх боломжийг бүрдүүлж бизнест учирдаг авилгын дарамтыг арилгана.

2.4 Чингис хотод Засгийн газрын дэмжлэг хөрөнгө оруулалтаар дулааны станцыг барьж хэрэглээний халуун усны хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр шийдвэрлэнэ .

2.5 Цэвэр бохир усны сүлжээний найдвартай байдлыг хангаж хуучин шугам сүлжээг засварлах ажлыг жил тутамд шинэчлэнэ.

2.6 Малын гаралтай түүхий эд, арьс ширний болон дайвар бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгох сум дундын үйлдвэрүүдийг бодлогоор дэмжин ашиглалтад оруулна.

2.7 Барилгын материалын орон нутгийн чанартай үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ. / блок-тоосго, хайрга, элс, цонх, хаалга, цемент, шахмал хавтан, төмөр,

2.8 Сум бүхэнд өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төмс хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлж хүлэмж, агуулах, зоориудын барьж байгуулна.





- 2.9 БорӨндөр суманд орон нутгаа хангах бичил оврын төмрийн үйлдвэр байгуулж, том оврын тээврийн нэгдсэн сүлжээг бий болгоно.
- 2.10 Аймгийн төв болон БорӨндөр, Бэрх зэрэг төвлөрсөн суурин газруудын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.
- 2.11 Уул уурхайн аливаа үйл ажиллагаанд нөхөн сэргээх, хөрсжүүлэн ургамалжуулах ажлыг гүйцэтгүүлэхийн зэрэгцээ дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг ашиглагчийн зайлшгүй гүйцэтгэх ажил болгоно.
- 2.12 Иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр ажиллах нөхцөлийг журамлаж гарал үүслийн гэрчилгээ олгох замаар дундын зуучлагч, ченжүүдийн хараанд орохоос урьдчилан сэргийлнэ.
- 2.13 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.14 Орон нутгийн чанартай зам гүүрийг засварлах, шинээр барьж байгуулна.
- 2.15 "1000 өрх орон сууц" хөтөлбөрийг сум бүхэнд хэрэгжүүлнэ. / хаус хороолол, түрээсийн гэх мэт/
- 2.16 Сумдад спорт заалыг шинээр барьж соёлын төвийг өргөтгөнө.
- 2.17 Чингис хот - Дадал чиглэлийн 265км, БорӨндөр Даланжаргалан чиглэлийн 50км хатуу хучилттай замыг барьж дуусгана.
- 2.18 Орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөж, 5G технологийг нэвтрүүлнэ.
- 2.19 Банкны үйлчилгээг нэмэгдүүлж Интернэт банк-АТМ ийг сум бүрт шинээр байршуулах.
- 2.20 Орон нутгийн шуудангийн тогтолцоог шинэчлэн сайжруулсанаар улсын түвшинд хүргэж, хүргэлтийн системийг сайжруулан шуудан түгээлтийг 3 дахин ихэсгэнэ.

ГУРАВ. НУТАГТАА ЭЗЭН ХЭНТИЙЧҮҮД /ЭЗЭН МОНГОЛ/

"Ажлын байр- Аймгийн хөгжил" чиглэлийг эрхэмлэн хөдөлмөрлөж, эдийн засгийн өсөлтийг өрх бүрээрээ хүртсэн бүтээгч Хэнтийчүүд ,бусдад жишиг байх үзэл баримтлалыг мөрдөн ажиллана.

- 3.1 Хэнтий аймаг нь эдийн засгийн бие даасан байдалыг эрхэмлэн байгалийн баялагаас улсын төсөвт орж байгаа орлогоос хүртэх хувиа нэмэгдүүлж экспортын чиг баримжаатай хөдөө аж ахуй-хөнгөн үйлдэрлэлийг хөгжүүлсэн аймаг болгох зорилтыг хэрэгжүүлнэ.
- 3.2 Хэнтий аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлана
- 3.3 Орон нутгийн хөгжлийн санг иргэдийн оролцоотой дүгнүүлдэг, үр ашигтай, хэмнэлттэй төсөв, аудит хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.4 Төрийн худалдан авалтын үйл ажиллгааг орон нутагтаа сонгон шалгаруулдаг, зөвхөн дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулдаг тогтолцоонд шилжинэ.
- 3.5 "Хашаандаа сайхан амьдаръя", "Жорлонгоо өөрчилъе" төслүүдийг сум бүрт хэрэгжүүлнэ.



- 3.6 Иргэдийн оролцоотой "Шинэ сум" хөтөлбөрийг аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан тодорхой дарааллаар хэрэгжүүлж эхлэнэ.
- 3.7 "Байгальд ээлтэй малчин" шалгаруулах журмыг аймгийн ИТХ-ээр батлан жил бүр шалгаруулж өндөр урамшил олгох.
- 3.8 Хэнтий аймгийн хэмжээнд мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай /орчин үеийн шинэ технологи, инновацид суурилан хөгжүүлж малчдыг малчин бизнесмэн болгох замаар тогтвортой орлоготой, хүчтэй дундаж давхаргыг бий болгох "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.9 Гал шарын ноолуурын чиглэлийн улаан ямааг омог болгон батлуулах ажлыг зохион байгуулна.
- 3.10 Малын тэжээл үйлдвэрлэлийг аймагтаа шинээр барих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.11 Сэргээгдэх эрчим хүчийг ашигласан усжуулалтын систем, худгийг өргөнөөр ашиглах боломжийг бүрдүүлнэ.
- 3.12 Экспортод чиглэсэн өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлнэ.
- 3.13 Малчин өрхийн 6-8 настай хүүхдийг гэрээр сургах гэрийн сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.14 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээрийн зохистой менежментийг боловсруулан баталж хэрэгжүүлж эхэлнэ.
- 3.15 Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийг иргэд малчдад таниулсанаар газар нутгийнхаа ан амьтан, ургамал, байгалын дагалт баялаг нь өөрийн эзэнтэй болох нөхцлийг бүрдүүлнэ.
- 3.16 Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өнгөт чулууг олборлон түүх, байгалын дагалт баялагуудыг зөвшөөрөлгүй бэлтгэх зэрэг зөрчлийг арилгахад зориулан тусгай журам гаргаж мөрдүүлнэ.
- 3.17 Аймгийн болон сумдын хилийн цэсийг тодотгон баталгаажуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 3.18 Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалтыг сайжруулсанаар жижиг дунд бизнес эрхлэгчдийг ажлын байраар хангана.
- 3.19 Сумын төвүүдийн төв замуудыг хатуу хучилттай болгон гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- 3.20 Аймгийн нутаг дэвсгэрт гадны малчидыг малаа оторлох тусгай журмыг хэлэлцэн баталж мөрдүүлэнэ.
- 3.21 Мах махан бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулан малыг эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.
- 3.22 Хэнтий аймаг нь Оросын холбооны улсын хил залгаа муж улсуудтай худалдааны таатай нөхцөл, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор хилийн боомт нээх ажлыг санаачлан эхлүүлнэ.



ЧУВАХ
МОНГОЛ

23171
ЮА0046

ДӨРӨВ.ХУУЛИЙГ ДЭЭДЛЭГЧ ХЭНТИЙЧҮҮД /ХУУЛЬТАЙ МОНГОЛ/
Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж хөгжлийг дэмжин, авлигаас ангид ажиллах чадавхитай засаг, хүн бүр ажил, албан тушаалаасаа үл хамаарч хуулийн өмнө хариуцлага хүлээдэг шударга шүүхийн тогтолцоо, мэргэжлийн хүртээмжтэй, цахимжсан нийтийн албыг бэхжүүлэх цогц шинэчлэл хийнэ.

4.1 Иргэн нь төрийн удирдах албан тушаалтанаас "Иргэний асуулга асуух эрх"-ийг баталгаажуулах эрхзүйн орчныг аймгийн хурлаар шийдвэрлүүлэн хэрэгжүүлнэ.

4.2 Хэрэг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэд цахимаар оролцох боломжийг бүрдүүлнэ

4.3 Хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүргийг иргэдийг дарамтлах, айлгах бус аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэхэд чиглүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс онцгой анхаарна.

4.4 Аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлийг дэмжихэд холбогдох хууль, дүрэм, журмыг тогтвортой ойлгомжтой байх хууль зүйн цогц шинэчлэл хийнэ.

4.5 Татвар, төрийн хяналт шалгалтыг /мэргэжлийн хяналт /иргэн, хуулийн этгээдэд зөвлөх, боломж олгох, дэмжих чиглэлээр шинэчлэн зохион байгуулна.

4.6 Авилга, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, ялгамжгүй, шударга, хүртээмжтэй хүнд сурталгүй хүргэнэ.

4.7 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, аюулгүй амар тайван амьдрах баталгааг хангахад чиглэсэн цогц арга хэмжээ авна.

4.8 Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлж архидалт, согтуурлын хор хөнөөлийг бууруулах ажлыг идэвхижүүлэнэ.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН ХЭНТИЙЧҮҮД

Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж хөгжлийг дэмжин, авлигаас ангид ажиллах чадавхитай засаг, хүн бүр ажил, албан тушаалаасаа үл хамаарч хуулийн өмнө хариуцлага хүлээдэг шударга шүүхийн тогтолцоо, мэргэжлийн хүртээмжтэй, цахимжсан нийтийн албыг бэхжүүлэх цогц шинэчлэл хийнэ.

5.1 Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгын зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргээх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдарлын чанарыг сайжруулсан байгальд ээлтэй "Ногоон аймаг" болно

5.2 Цөлжилттэй тэмцэх шинэ технологийг нэвтрүүлж, энэ чиглэлээрх олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

5.3 Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлнэ.

5.4 Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулна.



297
07408

- 5.5 Ой бүхий сумдад мэргэжлийн ойн анги байгуулж, хамгаалалтыг сайжруулахын зэрэгцээ нөхөрлөл, иргэдийн мод үржүүлгийн аж ахуйг онцгойлон дэмжинэ.
- 5.6 Аймгийн төвийн утааг бууруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүч, шинэ техник технологийг ашиглан дулаан, цахилгаан нийлүүлэх иргэд аж ахуй нэгжийг бодлогоор дэмжиж "Утаагүй хот" төслийг хэрэгжүүлнэ.
- 5.7 Аймгийн бүх сумдад "Ногоон гудамж", "Иргэн бүр-Нэг мод" төслүүдийг хэрэгжүүлэн үр дүнгээр нь урамшуулах ажлыг жил бүр хийнэ.
- 5.8 Аймгийн хэмжээнд байгаа гол, булаг, шанд, нуур, цөөрмийг хамгаалалтад авч байгалийн тэнцвэрт байдлыг хангана.
- 5.9 Дэлгэрхаан сумын Хэрлэн Баян Улаан уулыг тусгай хамгаалттай байгалийн нөөц газрын ангилалаар хамгаалалтад авна.
- 5.10 Аймгийн хэмжээнд орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад авсан газруудыг хамгаалах хамгаалалтын захиргааг байгуулан ажиллуулна.
- 5.11 Хэрлэн голын сав газрыг хамгаалах менежментийн төлөвлөгөөний дагуу хөв цөөрөм байгуулж усны нөөцийг хуримтлуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 5.12 Хэрлэн сумын хүн амыг цэвэр усны баталгаат эх үүсвэрээр хангах зорилгоор тусгай технологи бүхий 2-оос доошгүй гүний худаг гаргана.
- 5.13 Аймгийн төвийн ойролцоо сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрийг төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.
- 5.14 Хэрлэн голын зохистой орчинд хиймэл нуур бүхий ногоон орчин байгуулах, хотын хойно орших "Ташгай" толгой орчинд өвлийн амралт зугаалгын хүрээлэн бий болгож, иргэд залуусын чөлөөт цагаа өнгөрөөх орчныг бүрдүүлнэ.

Хэнтий аймгийн Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг төлөөлж

/тэмдэг/  ыг төлөөлжгарын үсэг

/тэмдэг/ыг төлөөлжгарын үсэг

2022 оны 04 сарын 12 өдөр